

## **ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ**

2018.04.16-04.20

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** Түүхий газрын тосны ханш өсөж байгаатай холбогдуулан эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш 2 долоо хоног дараалан өсжээ. Тамхи үйлдвэрлэгч Филипп Моррис Интернэйшнл компанийн хувьцааны ханш унаж өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш буурсан байна. Тус компанийн электрон тамхины Япон улсын зах зээл дэх борлуулалт таамаглаж байснаас илүү багасчээ. АНУ-ын 1-р улирлын эдийн засгийн тойм хувьцааны ханш өсөхөд нөлөөлсөн байна. АНУ-ын худалдааны борлуулалт гурван сарын турш унасны эцэст 3-р сард өсөв. Энэ долоо хоногт S&P 500 индексийн 69 компанийн 1-р улирлын тайлан гарсан. FactSet-ийн шинжээчдийн үзэж байгаагаар тус индекст багтдаг компаниудын 80%-ийнх нь нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ таамагласнаас өндөр үзүүлэлттэй байжээ.

**Европ:** Европын компаниудын хувьцааны ханш компаниудын 1-р улирлын тайлан болоод эдийн засгийн 1-р улирлын тойм гарсантай холбогдуулан өсөлттэй байлаа. Худалдааны дайны асуудал намжин АНУ-ын эрх бүхий албан тушаалтнууд НАФТА-гийн асуудалд нааштай хандаж байгаа талаар мэдэгдэл хийжээ. Долоо хоногийн дунд үеэс уул уурхай болон санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өссөн бол долоо хоногийн сүүлчээр өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч, байгалийн хий болон газрын тос олборлогч компаниудын хувьцааны ханш унасан байна.

Английн фунтын ханш суларсантай холбогдуулан FTSE 100 индекст багтдаг компаниудын ханш өсжээ. Тус компаниудын дийлэнх нь үндэстэн дамнасан компаниуд байдаг учир тэдгээрийн борлуулалтын орлого өссөн байна. Английн төв банкны тэргүүн энэ оны 5-р сард бодлогын хүүгээ өсгөхгүй байх магадлалтай хэмээн мэдэгдэл хийснээр фүнтийн ханш суларчээ.

**Япон:** Японы компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдлаа. Энэ долоо хоногт иений ханш тогтвортой байж ам. долларын эсрэг 107.7 нэгж болсон нь 2017 оны сүүлээс 4.5% өссөн байна. Энэ долоо хоногт БНХАУ болон Япон улс найман жилийн дараа анх удаа эдийн засгийн яриа хэлэлцэл хийлээ. АНУ-ын худалдаа, аюулгүй байдлын бодлого эрчимжсэнтэй холбоотойгоор Азийн тэргүүлэх эдийн засагтай хоёр улс харилцаагаа сэргээхийг зорьж байна.

**БНХАУ:** 2018 оны эхний гурван сарын байдлаар БНХАУ-ын эдийн засгийн өсөлт таамагласнаас өндөр үзүүлэлттэй байлаа. Хэрэглээний эрэлт өсөж, үйлдвэрлэлт сэргэж байгаа хэдий ч ирэх саруудад эдийн засгийн үзүүлэлт худалдааны маргаантай холбогдуулан саарах төлөвтэй байна. ДНБ өнгөрсөн оны 1-р улиралтай харьцуулахад 6.8%-аар өсжээ. Улирлын өсөлтийн дөрөвний гурваас илүү хувийг хэрэглээний өсөлт бүрдүүлсэн бөгөөд үүнд жижиглэнгийн интернет худалдаа ихээр нөлөөлсөн байна.

**Эх сурвалж:** Reuters, Troweprice

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,279.62	4.37% ▲
Dow Jones	АНУ	24,462.94	0.42% ▲
S&P 500	АНУ	2,670.14	0.52% ▲
Nasdaq	АНУ	7,146.13	0.56% ▲
S&P/TSX	Канад	15,486.00	1.39% ▲
FTSE 100	Их Британи	7,368.17	1.43% ▲
S&P/ASX 200	Австрали	5,868.80	0.24% ▲
Nikkei 225	Япон	22,162.24	1.76% ▲
Hang Seng	Хонг Конг	30,418.33	-1.27% ▼

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	112.41
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	98.31
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	97.42
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	115.32
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.33
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.62
TDBM' 2020	USD	9.3%	107.10

### Зах зээлийн хүү

ХҮҮ	Хаалт	ҮоҮ
Libor 1M	1.897	0.00% ▲
Libor 3M	2.359	0.01% ▲
Libor 6M	2.511	0.02% ▲
Libor 1YR	2.760	0.03% ▲
US 6M Bond	1.994	0.06% ▲
US 2YR Bond	2.462	0.10% ▲
US 3YR Bond	2.622	0.11% ▲
US 5YR Bond	2.805	0.12% ▲
US 10YR Bond	2.960	0.12% ▲

### Валютын ханш /төг/

Валют	2018.04.20	Өөрчлөлт
USD	2,394.96	0.04% ▲
CNY	380.91	-0.01% ▼
EUR	2,952.27	-0.06% ▼
RUB	38.99	-
KRW	2.24	-
JPY	22.27	0.13% ▲

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,334.21	-1.02% ▼
Мөнгө /spot/	17.06	2.28% ▲
Зэс	317.20	3.73% ▲
Нүүрс	93.45	1.22% ▲
WTI газрын тос	68.25	2.16% ▲
Brent газрын тос	73.98	2.96% ▲
Байгалийн хий	2.74	-

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляций түвшин	2018.11	6.90%
Бодлогын хүү	2018.11	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.11	11.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.11	12.90%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.11	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.11	19.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.11	11.50%

**Эх сурвалж:** Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 41 компанийн 6,758.9 сая төгрөгийн 16,048,696 ширхэг хувьцаа арилжигдав.


“Таван Толгой” /TTL/ компанийн хувьцаа 15.82%-аар буюу хамгийн ихээр өсч 10,470 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол савхи” /UYU/ компанийн хувьцаа 14.91%-аар буурч 782 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр мөн л арилжаа явагдаагүй байна.

4-р сарын 20-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,521.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,279.62 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 4.37%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	6,758.9
Зах зээлийн үнэлгээ	2,521,191.7

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,279.62	4.37% ▲
MSE I индекс	9,940.38	8.07% ▲
MSE II индекс	9,878.16	-1.66% ▼

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Монголын Цахилгаан холбоо	10,349,351	6,110,494,284.7
ЛендМН ББСБ	4,925,285	227,621,759.7
Таван Толгой	13,560	132,640,000.0
АПУ	151,096	97,793,441.6
Жинст-Увс	52,741	89,544,582.0

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Таван Толгой	10,470.00	15.82% ▲
Авто импекс	2,410.00	9.60% ▲
АПУ	657.19	8.85% ▲
Мах импекс	3,100.00	8.39% ▲
Монгол шуудан	589.96	6.78% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол савхи	782.00	-14.91% ▼
Улаанбаатар хивс	14,500.00	-14.71% ▼
Монгол нэхмэл	3,250.00	-13.33% ▼
Би Ди Сек	1,050.00	-12.43% ▼
Дархан нэхий	21,560.00	-10.61% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Гаули	12,282,338,492
БиДиСек	203,223,223
Мирэ Эссет Секьюритис Монгол	177,920,536
Ти Ди Би Капитал	174,682,024
Бумбат-Алтай	118,828,524

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	657.19	699,369
Таван толгой	10,470.00	551,405
МИК	11,250.00	232,980
Говь	21,760.00	169,752
Сүү	223.00	76,712

## ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

## КОМПАНИЙН БОНДЫН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Нийт ногдол ашиг /сая төг/	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	TTL	Таван Толгой ХК	ХЭХ-аар тогтооно		2018.03.16	2018.04.03	N/A
2	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	587.7	56.6	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
3	AEL	Анд-Энерги ХК	13.3	0.5	2018.02.24	2018.03.16	N/A
4	SUL	Жуулчин дүти фрийд ХК	653.6	10,000.0	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
5	SUU	Сүү ХК	1,032.0	3.0	2018.02.14	2018.04.05	2018.12.31-ний дотор
6	GTL	Гутал ХК	2,055.7	1,270.0	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
7	BNG	Баянгол Зочид буудал ХК	150.2	355.0	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
8	APU	АПУ ХК	10,641.8	10.0	2018.02.19	2018.03.29	2018.06.01-ний дотор
9	BTG	Баянтээг ХК	25.3	100.0	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
10	MIE	Материалимпекс ХК	13.7	10.0	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
11	MNP	Монгол шуудан ХК	367.2	3.7	2018.02.13	2018.04.13	2018.05.01-с
12	MMX	Махимпекс ХК	380.1	100.0	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
13	TCK	Талх чихэр ХК	174.0	170.0	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
14	GHC	Ган Хийц ХК	24.2	100.0	2018.02.09	N/A	N/A
15	ADL	Адуун чулуун ХК	409.6	130.0	2018.01.24	2018.03.01	N/A
16	UBH	Улаанбаатар хивс ХК	40.4	100.0	2018.02.05	2018.02.26	2018.05.01-ний дотор
17	ТАН	Тахь-ко ХК	128.5	108.0	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
18	GOV	Говь ХК	1,716.2	220.0	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с
19	HRM	Гермес Центр ХК	392.7	5.0	2018.01.24	2018.02.15	2018.03.06-с

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр		№	Симбол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр	
1	DAZ	Дорнод авто зам	2018.03.12	2018.04.09	15:00	13	HTS	Хөтөлийн цемент шохой	2018.03.28	2018.04.16	10:00
2	GTL	Гутал	2018.03.18	2018.04.09	15:00	14	HUV	Хөвсгөл геологи	2018.03.29	2018.04.17	10:00
3	HUZ	Хөвсгөл усан зам	2018.02.26	2018.04.09	-	15	GOV	Говь	2018.03.27	2018.04.17	14:00
4	UBH	Улаанбаатар хивс	2018.02.26	2018.04.10	11:00	16	HVL	Хөвсгөл	2018.03.28	2018.04.17	14:00
5	OLL	Оллоо	2018.03.19	2018.04.10	14:00	17	HNS	Хөвсгөл хүнс	2018.03.28	2018.04.17	17:00
6	ALI	Стандарт Ноос	2018.02.26	2018.04.10	15:00	18	TGS	Номин Хишиг	2018.03.29	2018.04.18	10:00
7	HRL	Хэрлэн хивс	2018.03.19	2018.04.10	-	19	SOR	Сор	2018.03.28	2018.04.18	10:00
8	ETR	Э-Транс ложистикс	2018.03.23	2018.04.11	10:00	20	ARH	Сэлэнгэ Ар Хөвч	2018.03.30	2018.04.18	14:00
9	HUN	Увс хүнс	2018.03.23	2018.04.13	9:00	21	HHN	Хархорин	2018.03.30	2018.04.18	14:00
10	BRC	Барилга Корпораци	2018.03.16	2018.04.14	10:00	22	MIE	Материалимпекс	2018.03.26	2018.04.20	10:30
11	DBL	Даваанбулаг	2018.03.24	2018.04.14	14:00	23	TAV	Тав	2018.03.28	2018.04.20	11:00
12	TEX	Техник импорт	2018.03.28	2018.04.16	15:00						

№	Сим бол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр		№	Сим бол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр	
24	APU	АПУ ХК	2018.03.29	2018.04.20	15:00	70	JLT	Ногоон хөгжил үндэсний нэгдэл	2018.03.22	2018.04.28	14:00
25	NOG	Ачит Алкабы	2018.03.27	2018.04.20	15:00	71	TUS	Түшиг Уул	2018.03.29	2018.04.28	14:00
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ	2018.03.27	2018.04.20	16:00	72	MOG	Монгео	2018.04.09	2018.04.29	9:00
27	HSG	Хөсөг трейд	2018.03.23	2018.04.21	12:00	73	HCH	Е-Моние	2018.04.08	2018.04.29	11:00
28	AEL	Анд-Энерги	2018.03.16	2018.04.21	12:00	74	HBZ	Хүннү менежмен	2018.04.08	2018.04.29	11:00
29	CHR	Увс Чацаргана	2018.03.23	2018.04.22	11:00	75	DAR	Дархан гурил тэжээл	2018.04.10	2018.04.29	13:00
30	BNB	Баялаг Налайх	2018.03.30	2018.04.22	15:00	76	DOT	Дорнод тээвэр	2018.04.08	2018.04.29	14:00
31	BDS	Би Ди Сек	2018.04.02	2018.04.23	10:00	77	TVT	Хар тарвагатай	2018.04.09	2018.04.29	15:00
32	SDT	Хот девелопмент	2018.04.03	2018.04.23	10:00	78	HSR	Хасу-Мандал	2018.03.23	2018.04.29	15:00
33	BEU	Бэрх Уул	2018.04.03	2018.04.23	12:00	79	SUL	Жуулчин дюти фрии	2018.04.11	2018.04.30	10:00
34	MNS	Монноос	2018.03.31	2018.04.23	15:00	80	DMA	Дэвшил Мандал	2018.04.06	2018.04.30	9:00
35	UYN	Монгол савхи	2018.04.05	2018.04.24	10:00	81	NXE	Нэхээсгүй эдлэл	2018.04.06	2018.04.30	9:00
36	JGV	Жуулчин говь	2018.04.05	2018.04.24	13:00	82	ALA	Алтайн Нэгдэл	2018.03.30	2018.04.30	10:00
37	MNG	Мандал говь импекс	2018.04.05	2018.04.24	15:00	83	BAZ	Люкс зананду групп	2018.04.06	2018.04.30	10:00
38	BHG	Бөхөг	2018.03.23	2018.04.25	10:00	84	MIK	МИК Холдинг	2018.04.11	2018.04.30	10:00
39	TAN	Тахь-ко	2018.03.30	2018.04.25	10:00	85	MNP	Монгол шуудан	2018.04.13	2018.04.30	10:00
40	BBD	Стандарт проперти групп	2018.04.10	2018.04.25	11:00	86	TMZ	Төмрийн завод	2018.04.09	2018.04.30	10:00
41	BUK	УБ-БҮК	2018.04.03	2018.04.25	11:00	87	NRS	Шинэст	2018.04.10	2018.04.30	10:00
42	BDL	Могойн гол	2018.04.04	2018.04.25	12:00	88	BAN	Багануур	2018.04.13	2018.04.30	11:00
43	EER	Ариг гал	2018.04.02	2018.04.25	17:00	89	GTJ	Булган гурил тэжээл	2018.04.06	2018.04.30	11:00
44	HJL	Орхон хөгжил	2018.04.03	2018.04.25	-	90	BLC	Бүтээлч үйлс	2018.04.05	2018.04.30	11:00
45	MMX	Махимпекс	2018.04.05	2018.04.26	14:00	91	JGL	Говийн өндөр	2018.04.09	2018.04.30	11:00
46	TTL	Таван Толгой	2018.04.03	2018.04.26	14:00	92	MCH	Монголын цахилгаан холбоо	2018.04.06	2018.04.30	11:00
47	SHG	Шарын гол	2018.04.02	2018.04.26	15:30	93	RMC	Ремикон	2018.04.12	2018.04.30	11:00
48	BNG	Баянго зочид буудал	2018.04.06	2018.04.26	16:00	94	SOH	Уужим Хангай	2018.04.12	2018.04.30	11:00
49	MBG	Мон-Ит Булигаар	2018.04.05	2018.04.27	9:00	95	EAZ	Эрдэнэт авто зам	2018.04.06	2018.04.30	11:00
50	JTB	Женко Тур Бюро	2018.04.04	2018.04.27	10:00	96	BAJ	Баялаг-Сүмбэр	2018.04.12	2018.05.01	11:00
51	UID	Улсын их дэлгүүр	2018.03.30	2018.04.27	10:00	97	NKT	Нако Түлш	2018.04.03	2018.04.30	12:00
52	BUN	Булган ундрага	2018.04.06	2018.04.27	11:00	98	АНН	Хорин хоёрдугаар бааз	2018.03.23	2018.04.30	13:00
53	ERS	Монгол алт	2018.04.05	2018.04.27	11:00	99	HZB	Ган хэрлэн	2018.04.06	2018.04.30	14:00
54	MNH	Монгол Нэхмэл	2018.03.30	2018.04.27	11:00	100	INT	Ингэттолгой	2018.04.09	2018.04.30	14:00
55	MIB	Монинжбар	2018.03.20	2018.04.27	11:00	101	MSH	Монгол шилтгээн	2018.04.06	2018.04.30	14:00
56	CHE	Хорго Хайрхан	2018.04.06	2018.04.27	11:00	102	HBO	Хай би ойл	2018.04.10	2018.04.30	14:00
57	SUN	Евроази капитал холдинг	2018.03.20	2018.04.27	12:00	103	HGN	Хөх ган	2018.04.06	2018.04.30	14:00
58	BOE	Эрчим баян өлгий	2018.04.05	2018.04.27	12:00	104	SHV	Шивээ овоо	2018.04.05	2018.04.30	14:00
59	ALD	Азык	2018.03.28	2018.04.27	14:00	105	JRG	Эвлэл	2018.04.09	2018.04.30	14:00
60	ATR	Атар-Өргөө	2018.04.10	2018.04.27	14:00	106	TAS	Эрдэнэт хүнс	2018.03.31	2018.04.30	14:00
61	DZG	Дархан зочид буудал	2018.03.28	2018.04.27	14:00	107	ITLS	Айтүүлс	2018.04.06	2018.04.30	15:00
62	GFG	Силк нэт	2018.03.20	2018.04.27	14:00	108	GUR	Гурил	2018.04.07	2018.04.30	15:00
63	TCK	Талх Чихэр	2018.04.06	2018.04.27	14:00	109	SUU	Сүү	2018.04.05	2018.04.30	15:00
64	TEE	Тээвэр дархан	2018.04.05	2018.04.27	14:00	110	MDR	Фронттиер лэнд групп	2018.04.06	2018.04.30	15:00
65	DHU	Дархан Хүнс	2018.04.05	2018.04.27	14:00	111	HAM	Монголын хөгжил үндэсний нэгдэл	2018.04.09	2018.04.30	17:00
66	MRX	Мерекс	2018.04.07	2018.04.28	10:00	112	BSKY	Блюскай секьюритиз	2018.03.30	2018.04.30	18:00
67	ECV	Эрээнцав	2018.04.09	2018.04.28	11:00	113	ONH	Өндөрхаан	2018.04.12	2018.04.30	13:00
68	AMT	Хар хорум пропертийс	2018.04.09	2018.04.28	12:00	114	HTS	Хөтөлийн цемент шохой	2018.04.17	2018.05.07	10:00
69	MBG	Жинст-Увс	2018.04.12	2018.04.28	14:00	115	LND	ЛендМН ББСБ	2018.04.11	2018.05.10	18:00



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт орлоо

Монгол Улсын Засгийн Газар болон БНСУ-ын “Кореа Телеком” ХК-ийн хооронд байгуулагдсан гэрээний дагуу Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн 40 хувийг Монгол Улсын Засгийн газарт худалдах багцын арилжаа 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр явагдсанаар тус компани дахь Монгол Улсын Засгийн Газрын эзэмшлийн хувь 94.67 хувьд хүрлээ.

**Эх сурвалж:** MSE.mn

### Монголын хөрөнгийн биржийн 2017 оны жилийн тайлан нийтлэгдлээ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2017 оны ололт, амжилт, онцлог үйл явдлууд болон санхүүгийн үзүүлэлт бүхий “Жилийн тайлан-2017” нийтлэгдлээ.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 2017 онд 76.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцаа, 772.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Засгийн газрын бонд, 10.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий компанийн бонд буюу нийтдээ 859.2 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн нь түүхэндээ хамгийн их арилжаа хийсэн жил боллоо. Засгийн газрын бондын хоёрдогч зах зээлийн арилжаа урьд өмнө байгаагүйгээр идэвхжиж, ТОП-20 индекс, зах зээлийн үнэлгээ сүүлийн 5 жилийн хамгийн дээд үзүүлэлтэд хүрсэн зэргээс гадна шинээр болон нэмж үнэт цаас гаргах зэрэг олон үйл ажиллагаа амжилттай явагдсан билээ. Тухайлбал, “Сүү” ХК-ийн гаргасан “Сүү бонд” 6.0 тэрбум төгрөгийг амжилттай босгож, хамгийн өндөр үнийн дүнтэй компанийн өрийн хэрэгсэл гаргасан компани болсон бол МХБ-д бүртгэгдсэн хамгийн анхны мэдээлэл технологийн компани болох “Айтүүлс” ХК-ийн анхдагч зах зээлийн үнэт цаас худалдан авах захиалга нь нийлүүлэлтээсээ 3 дахин их буюу 3.9 тэрбум төгрөгт хүрсэн нь Монголын хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргасан компаниуд дунд хамгийн их захиалга авсан компани боллоо.

Мөн МХБ-ийн 1-рангилалд бүртгэлтэй “АПУ” ХК нь “Эвэргрийн” ХК-ийг өөртөө нэгтгэх замаар компанийн хэлбэрээ өөрчлөн байгуулж, хаалттай хүрээнд 321,304,553 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргасан нь Монголын хөрөнгийн зах зээлд хамгийн том хэмжээний нэгдэл болсон юм. Тус нэгдлийн үр дүнд олон улсад нэр хүнд бүхий “Хайнекен” компани “АПУ” ХК-ийн хувьцааны 25%-ийг эзэмших болсон бөгөөд “АПУ” ХК нь бүс нутгийн болон олон улсын зах зээлд гарч бизнесийн үнэ цэнээ өсгөх боломж нээлттэй боллоо.

Түүнчлэн, МХБ нь Санхүүгийн зохицуулах хороотой хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж, үнэт цаасны давхар бүртгэлийг зохицуулах журмыг батлуулснаар Монголын хөрөнгийн зах зээлд хамгийн анхны давхар бүртгэгдсэн компанийн үнэт цаасыг арилжих нөхцөлийг амжилттай бүрдүүлжээ.

**Эх сурвалж:** MSE.mn



### “Шарын гол” ХК: 2018 онд 1.06 сая тонн нүүрс олборлоно

Монголын Хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй “Шарын гол” компани 2018 онд өмнөх оноос 100 мянган тонноор их буюу 1.06 сая тонн нүүрс олборлохоор төлөвлөсөн байна. Үүнээс 1.04 сая тонныг нь борлуулахаар тооцоолжээ. Тус компани үнэ ханш өсөлттэй байсан 2017 онд сүүлийн 14 жилийн дээд хэмжээ буюу 912 мянган тонн нүүрс олборлож, 909 мянган тонн нүүрс борлуулсан байна.

“Эрдэнэт” үйлдвэрийн станцын өргөтгөл ашиглалтад орсноор олборлолт болоод борлуулалтыг дэмжихэд нөлөөлсөн талаар “Шарын гол” компани мэдээлж байсан юм. 2017 онд “Шарын гол” компани 48.9 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оноос 52 хувиар өссөн байна. Эрдэнэт, Дарханы Дулааны цахилгаан станц болон “Эрдэнэт” үйлдвэр 805 мянган тонн нүүрс худалдан авсан нь нийт борлуулалтын 88.5 хувийг эзэлжээ. Мөн Дарханы Дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 мегаваттаар өргөтгөх төсөл хэрэгжиж байна. Ингэснээр нүүрсний хэрэгцээ нэмэгдэх төлөвтэй байгаа гэж үзэж байгаа ажээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### “Ремикон” ХК: 2018 онд бетон зуурмагийн борлуулалтаа 50 хувиар нэмэгдүүлнэ

“Ремикон” компани 2018 онд 90 мянган метр куб бетон зуурмаг борлуулахаар төлөвлөсөн талаар мэдээллээ. Өөрөөр хэлбэл томоохон төслүүдэд оролцохоор болсон тул өнгөрсөн оноос төлөвлөлтөө 50 хувиар нэмэгдүүлсэн байна. 2017 онд тус компани 54.8 метр куб бетон зуурмаг борлуулж, 7.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж байжээ. Энэ нь төлөвлөснөөс 8.6 хувиар бага үзүүлэлт болсон байна. “Ремикон” компани өнгөрсөн 2017 онд бетон зуурмагийн хөндлөнгийн хяналт үйлчилгээ явуулах эрхтэй итгэмжлэгдсэн лабораторийн эрх авсан юм. Ингэснээр энэ онд бетон зуурмагийн болон түүхий эд материалын сорилт шинжилгээ хийж ажиллахаар зорьж байгаа ажээ. Дөрөвдүгээр сарын нэгнээс албан ёсоор сорилт шинжилгээний ажил эхэлж, одоогоор хоёр үйлдвэртэй хамтран ажиллаж байгаа талаар тус компани мэдээллээ.

Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны мэдээллээр дотоодод бетон зуурмагийн 158 үйлдвэр бүртгэлтэй байгаа бөгөөд 2017 онд 54 үйлдвэр үйл ажиллагаа явуулсан байна. “Ремикон” компанийн бетон зуурмагийн үйлдвэр зах зээлийн 6.1 хувийг эзэлж байгаа аж.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Адуунчулуун ХК: 2017 онд нүүрсний борлуулалт 10 хувиар буурсан

8.2 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй “Адуунчулуун” компани 2017 онд 510.5 мянган тонн нүүрс олборлон борлуулсан байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс 10.3 хувиар буурсан дүн болжээ. Тус компани 2017 оны нийт борлуулалтын 83 хувийг дангаараа бүрдүүлсэн “Дорнод бүсийн эрчим хүчний систем” Төрийн өмчит хувьцаат компанид 500 мянган тонн нүүрс борлуулахаар гэрээ байгуулсан ч 424 мянган тонн нүүрс борлуулсан нь төлөвлөснөөс 75.8 мянган тонноор буурчээ.

Үүнээс гадна МАК компани өөрийн эзэмшлийн талбайгаас “Дорнод бүсийн эрчим хүчний систем” компанид туршилтаар нүүрс борлуулж эхэлсэн нь “Адуунчулуун” компанийн борлуулалтад нөлөөлсөн байна. “Адуунчулуун” ХК Монгол Улсын зүүн бүсийг эрчим хүчний нүүрсээр хангагч гол компани бөгөөд 2000 оноос техникийн шинэчлэл хийгдснээр жилд нэг сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай болжээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Монгол улс шатахууны 40 хоногийн нөөцтэй гэв

Улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 40 хоногийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгааг салбарын яамнаас мэдээллээ.

Тодруулбал А-80 автобензин 77, Аи-92 автобензин 30, дизелийн түлш 41, ТС-1 онгоцны түлш 29 хоногийн нөөцтэй байгаа аж.

Манай улс энэ онд 8.1 сая баррель буюу 1.1 сая тонн газрын тос олборлож 223.4 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөөд байгаа аж. Энэ сарын 11-ний байдлаар 1.93 сая баррель буюу 262 мянган тонн тос олборложээ. Ингэснээр эхний улирлын байдлаар улсын төсөвт 53.3 тэрбум төгрөг төвлөрүүлж 23.86 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Эх сурвалж:** Montsame.mn

### Гашуунсухайт-Ганцмод боомтоор өдөрт 1000 гаруй автомашин хил нэвтэрч байна

БНХАУ-ын талын Ганцмод боомтоор нүүрс тээвэрлэж байгаа автомашинуудыг нэвтрүүлэх гарцыг гурав болгон нэмснээс хойш өдөрт 1000 гаруй автомашин хил нэвтэрч байна. Зөвхөн пүрэв гарагт л гэхэд Гашуунсухайт-Ганцмод боомтоор нүүрс тээврийн 1012 автомашин нэвтэрч гарсан талаар Гашуунсухайт боомтын захиргаа мэдээллээ. Үүнээс 780 буюу 77 хувь нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийнх, 191 буюу 19 хувь нь "Энержи Ресурс" ХХК, үлдсэн нь орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК-ийнх байгаа аж. Харин пүрэв гарагт БНХАУ-ын талын Ганцмод боомтын нэг гарцын хаалгыг автомашин мөргөсний улмаас чөлөөт нэвтрүүлэх боломж нь хязгаарлагдсан байна. Үүнээс болж БНХАУ-ын тал руу нэвтэрсэн нүүрс тээврийн автомашинууд буцаж хилээр ороход хүндрэлтэй болжээ. Гэхдээ пүрэв гарагийн орой гэхэд нийт 830 автомашин Гашуунсухайт-Ганцмодоор хил нэвтрэн орж ирсэн талаар боомтын захиргаа мэдээллээ. Мөн холбогдох засварын ажлыг өнөөдөр хийж гүйцэтгэх юм байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### TRQ: "Оюу Толгой"-ийн зэсийн гарц | улиралд 14.3 хувиар буурав

"Оюу Толгой"-ийн үйлдвэрлэл болон баяжмалын агууламж буурснаас хамаарч I улиралд зэсийн гарц нь 14.3 хувиар багассан талаар "Turquoise Hill Resources" компани мэдээллээ. Харин илэрц нэмэгдсэнээс гадна алтны агууламж өссөн зэрэг нь алтны гарц 20 хувиар нэмэгдэхэд нөлөөлсөн байна. I улиралд "Оюу Толгой" ХХК нийт 38.8 мянган тонн зэс, 42 мянган унц алт бүхий баяжмал боловсруулжээ. "Оюу Толгойн бүтээгдэхүүний гарц I улиралд хүлээж тооцож байсантай дүйцсэн" гэж "Turquoise Hill Resources"-ийн Гүйцэтгэх захирал Жефф Тайгесен онцолсон байна. Мөн тэрбээр "Нэгдүгээр сард төлөвлөсний дагуу зарим засварын ажлыг гүйцэтгэсэн нь I улирлын хэмжээнд үйлдвэрлэл буурахад нөлөөлсөн. Гэхдээ алтны гарц өссөн" гэж мэдэгдлээ. "4A хэсэг дэх хүдрийн эхний шатны боловсруулалтаас харахад өнгөрсөн онтой харьцуулахад алтны агууламж, үйлдвэрлэлд өсөлт ажиглагдаж байгаа" гэж үзсэн байна. Цаг агаарын нөхцөл байдал болон төлөвлөгөөт засварын ажил зэргээс хамаарч үйлдвэрлэл 20 хувиар буурсан байна. "Оюу Толгой" ХХК-ийн хувьд 2018 онд 125-155 мянган тонн зэс, 240-280 мянган унц алт бүхий баяжмал боловсруулахаар төлөвлөж байгаа ажээ.

Хамгийн сүүлд Торонтогийн Хөрөнгийн биржид "Turquoise Hill Resources"-ийн хувьцааны ханш 3.84 канад доллар болсон байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



### Xanadu Mines: "Хармагтай" ордод зэс порфирын шинэ талбай илрүүлээ

Өмнөговь аймгийн нутагт байрлах "Хармагтай" ордод хийж байгаа хайгуулын үеэр порфир зэсийн шинэ талбайг олж илрүүлсэн талаараа "Xanadu Mines" компани мэдээллээ.

"Зараа" гэж нэрлэгдэж байгаа энэхүү талбайд 316 метрийн гүнд 0.32 хувийн агууламжтай зэс, 458 метрийн гүнд тонн хөрс тутмаас 0.26 грамм алтны илэрц олдсон байна. Цаашид өрөмдлөгөө үргэлжлүүлж 1200 метрт хүргэхээр төлөвлөжээ. Эцсийн шинжилгээг тавдугаар сарын эхээр гаргана гэж тус компани мэдээллээ. "Хармагтай" талбайд 2018 оны туршид хайгуулаа үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа "Xanadu Mines" компанийн хувьцааны ханш Австралийн Хөрөнгийн биржийн пүрэв гарагийн арилжаа эхлэх үед 8.11 хувиар өсөж, 0.02 австрали доллар боллоо.

**Эх сурвалж:** Montsame.mn

### LME: Кобальтын ханш 2016 оны эхэн үеэс хойш 300 хувиар өсөөд байна

Кобальтын салбарт тэргүүлэгчдийн нэг "Cobalt 27 Capital" компани БНХАУ-ын томоохон компаниудад урт хугацааны турш кобальт нийлүүлэх гэрээ хийхэд ойрхон байгаагаа мэдэгдсэн байна. Цахилгаан автомашины үйлдвэрлэлээр БНХАУ дэлхийд тэргүүлэх нь нэгэнт ойлгомжтой болоод байгааг компанийн удирдлагууд онцлоод, тус улсын компаниудтай найдвартай түншлэлийн гэрээ байгуулах сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. Үүнээс өмнө кобальтын нөөцөөрөө дэлхийд тэргүүлэгч "Glencore" компани Тонго улс дахь кобальтын ордоо БНХАУ-д худалдаж магадгүй байгаагаа мэдэгдэж байсан юм. Ийнхүү БНХАУ дэлхийн кобальтын нөөцийн дийлэнх хувийг эзэмшдэг болбол Европын Холбооны улсууд цахилгаан автомашин үйлдвэрлэлээрээ БНХАУ-тай өрсөлдөх ямар ч боломжгүй болохыг "Glencore"-ийн захирал анхааруулж байсан удаатай аж.

Ухаалаг гар утас, цахилгаан автомашины зай хураагуурын гол элемент болоод байгаа кобальтын ханш 2016 оны эхэн үеэс хойш 300 гаруй хувиар огцом өсжээ. Энэ нь кобальтын ханш сүүлийн 10 жилийн дээд цэгтээ хүрч өссөн тохиолдол болж байна. Хамгийн сүүлийн ханшаар тонн тутам нь 91 мянга 500 ам.долларт хүрээд байгаа юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Troweprice: Хөнгөн цагаан, палладин болон никелийн ханш өсжээ

Өнгөрсөн долоо хоногт ОХУ-ын хөнгөн цагаан үйлдвэрлагч Rusal компанийн нөлөө бүхий хоёр хувьцаа эзэмшигч нь АНУ-ын хоригийн жагсаалтанд багтсанаар тус компани бүтээгдэхүүнээ АНУ болон бусад орнуудад нийлүүлэх боломжгүй болсон. Үүнтэй холбогдуулан хөнгөн цагааны ханш огцом өссөн билээ. Сүүлийн хоёр долоо хоногийн байдлаар Лодонгийн металлын бирж дээр хөнгөн цагааны ханш 20% өссөн бол палладин болон никелийн ханш 13% болон 14%-аар тус тус өссөн байна. Дэлхийн палладины 40%-ийг дангаараа үйлдвэрлэдэг Норильск Никель компанид хориг тавих магадлалтай хэмээн хөрөнгө оруулагчид үзсэн учир палладин болон никелийн үнэ өсжээ.

**Эх сурвалж:** Troweprice.com

## БУСАД МЭДЭЭ



### Дотоодын ААН-үүдийн тоо өсөж буй ч “ажилгүй” компаниудын тоо нэмэгдсээр

2016 онд нэг хувь болж саарсан дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2017 онд 5.1 хувьд хүрээд байна. Эдийн засгийн өсөлт ийнхүү сэргэсний дараа буюу 2018 оны эхний гурван сарын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 7766-аар нэмэгджээ. Эдгээрийн 85.5 хувь нь 0-9 ажилтантай жижиг компаниуд байгаа бол 50-иас дээш ажилтантай компаниуд 3.1 хувийг эзэлж байгааг Бизнес регистрийн сангийн мэдээллээс харж болохоор байгаа юм. Энэ оны гуравдугаар сарын байдлаар дотоодод 158.8 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 51 хувь нь үйл ажиллагаагаа явуулж байна. Бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2015 оноос хойш 26.4 хувиар өсжээ. Гэхдээ үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжийн тоо мөн адил 27.4 хувиар өссөн байна. Үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2017 оны эхний гурван сарын байдлаар 49.6 хувьд хүрч өссөн нь сүүлийн дөрвөн жилд ажиглагдсан хамгийн тааруу дүн болж байгаа аж. Үүнээс өмнө буюу 2016 онд эдийн засгийн өсөлт нэг хувь буюу 2009 оноос хойших хамгийн доод түвшинд хүрсэн юм.

Дэлхийн банкнаас жил бүр гаргадаг “Doing Business-2018” тайланд Монгол Улс 69.03 оноо авч, 109 орноос 62 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Энэ нь өмнөх оныхоос бага зэрэг сайжирсан үзүүлэлт болжээ. Шинээр бизнес эхлүүлэхэд хялбар байдал өнгөрсөн оныхоос өөрчлөгдөлгүй 90.08 нэгжид хадгалагдсан бол барилгын зөвшөөрөл авахад хялбар байдлаар Монгол Улс дэлхийн орнуудаас 23 дугаарт бичигдэж байна. Харин 2012 онд 119 дүгээрт бичигдэж байжээ.

Мөн зээл авахад хялбар байдал 20 хувиар нэмэгдэж, 80 нэгжид хүрсэн байна. Энэ үзүүлэлтээрээ Монгол Улс 190 орноор 20 дугаарт эрэмбэлэгдсэн нь анхаарал татаж байна. Харин “Transparency International” олон улсын байгууллагаас гаргадаг “Авлигын төсөөллийн индекс”-ээр Монгол Улс хоёр жил дараалан сөрөг дүн үзүүлж, 103 дугаарт эрэмбэлэгдэж байна. Тиймээс авлигын орчныг бүрдүүлэхгүй байх, бизнесийн салбарт чөлөөт өрсөлдөөнийг бий болгож, худалдан авалт, төсвийн зарцуулалтыг хариуцлагатай, ил тод болгох шаардлагатай гэдгийг тус байгууллагаас сануулсан юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Монголбанк 176.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ

Монголбанк 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, хөндлөнгийн аудитын PWC Mongolia компаниар баталгаажуулжээ.

Тайлант хугацаанд Монголбанк 176.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, 2012-2016 онд хуримтлагдсан 3.0 их наяд төгрөгийн алдагдлыг 2.8 их наяд төгрөг болгон бууруулсан байна.

Үйл ажиллагааны үр дүн ашигтай гарахад дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тодруулбал, Монголбанк алт худалдан авах үнийг дэлхийн зах зээлийн ханштай нийцүүлж, нийт 20 тонн алт худалдан авсан нь манай түүхэн дээд хэмжээ байсан бөгөөд дэлхийн зах зээл дээрх алтны үнэ оны эхнээс 10 орчим хувиар өссөн нь үнэт металлын арилжааны орлого нэмэгдэх, нөөц өсөхөд гол нөлөө үзүүлсэн байна.

Оны эцэст гадаад валютын улсын нөөц гурван тэрбум ам.долларт хүрч, төгрөгийн ханш чангарснаар макро эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлж, улмаар Монголбанкны бодлогын шинж чанартай үйл ажиллагааны орлого, зарлагын урсгалыг сайжрууллаа.

Дотоодын банкуудад олгосон зээл, Засгийн газрын үнэт цаас, Ипотекийн зээлээр баталгаажсан бондын хүүгийн орлого 2016 онтой харьцуулбал 50 гаруй хувиар өссөний зэрэгцээ, санхүүгийн дериватив хэлцлийг дахин үнэлэх арга, загварчлалыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан илүү бодитой болгон сайжруулсан нь үйл ажиллагааны үр дүн ашигтай гарахад чухал нөлөө үзүүлжээ.

**Эх сурвалж:** Montsame.mn

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.